



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И мэйл: ub@audit.gov.mn, Вебсайт: www.audit.mn

2024. 02. 23

№

321

танай _____-ны № _____ -т

НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА, ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧ Ж.ГАНБОЛД ТАНАА

2023 оны санхүүгийн тайлан, төсвийн
гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан, санал
дүгнэлтийг хүргүүлж байна.

Хавсралт . . . ²⁵ хуудастай:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

002033149



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийслэлийн биеийн тамир спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2024/229/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn
Улаанбаатар хот
2023 он

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн: Шонхор үнэлгээ аудит ХХК
Захирал: Д.Шийрэв
Утас: 88880963 Цахим хаяг: shonkhor.mn@gmail.com
Аудитын менежер: Д.Уранчимэг
Утас: 94064222 Цахим хаяг: urmaa.5804@yahoo.com
Ахлах аудитор: Ц.Орхонтамир
Утас: 99005577 Цахим хаяг: audit.rusbd@gmail.com
Аудиторын туслах: Б.Цэрэнлхам
Утас: 80110088 Цахим хаяг: amuaudit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1. Хараат бус аудиторын дүгнэлт
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....
 - 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа
 - 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин
 - 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал
 - 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт
4. Аудитын тайлан
- 4.1 Ерөнхий зүйл
- 4.2 Материаллаг байдал
- 4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....
- 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал
- 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
5. Аудитын илрүүлэлт
6. Аудитаар илэрсэн буруу илэрхийллийн нэгтгэл

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2024. 02. 23 № 322

танай _____-ны № _____-г

НИЙСЛЭЛИЙН БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ
Ж.ГАНБОЛД ТАНАА

АУДИТЫН ДҮГНЭЛТ

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Нийслэлийн биеийн спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Нийслэлийн биеийн тамир спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Санхүүгийн тайлангийн тухай болон аудитын тайлангийн тухай хэрэглэгчдийн анхаарал хандуулах, ач холбогдолтой зүйлийн талаар тодруулахад санхүүгийн тайланд толилуулаагүй асуудал гараагүй болно.

Тус байгууллага нь санхүүгийн тайлангаа бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг ашигласан байна. Цаашид тус газрын талаар чиг үүрэг нь өөрчлөгдөж татан буугдах, нэгдэх асуудал гараагүй тул байгууллагын тасралтгүй байдлын талаар нөхцөл үүсээгүй гэж үзсэн болно.

Аудитын гол асуудал

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай зохистой нотолгоо олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй зохистой гэж үзлээ.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Биеийн тамир, спортын газар нь тайлант онд 10 зорилтын хүрээнд 56 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 95.2 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>9,485,766.90</u>	<u>22,084,844.90</u>
	МӨНГӨ ТҮҮНТЭЙ АДИЛТГ		<u>1,474,850.00</u>
	АХ ХӨРӨНГӨ		<u>1,474,850.00</u>
312	Банкинд байгаа бэлэн мөнгө		<u>1,474,850.00</u>
3121	төгрөг		<u>1,474,850.00</u>
31211	Төрийн сангийн харилцах		
ДТ(312114)	Бусад төсөл нөөцийн харилцах		1,474,850.00
35	БАРАА МАТЕРИАЛ	9,485,766.90	20,609,994.90
354	Хангамжийн материал	9,485,766.90	20,609,994.90
35410	Бичиг хэргийн материал	1,000,000.00	908,800.00
35420	Аж ахуйн материал	3,766,700.00	4,135,900.00
35470	Бусад хангамжийн материал	4,719,066.90	15,565,294.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>171,735,037.89</u>	<u>215,224,228.27</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	<u>171,735,037.89</u>	<u>215,224,228.27</u>
392	Биет хөрөнгө	<u>18,935,037.89</u>	<u>62,424,228.27</u>
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	41,755,237.92	72,289,337.92
39206	Хуримтлагдсан элэгдэл	(27,853,846.39)	(33,560,429.08)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	14,883,879.90	34,630,104.90
39208	Хуримтлагдсан элэгдэл	(9,850,233.54)	(10,934,785.47)
393	Биет бус хөрөнгө	<u>152,800,000.00</u>	<u>152,800,000.00</u>
39301	Программ хангамж	3,280,000.00	3,280,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	(1,780,000.00)	(1,780,000.00)
39303	Бусад биет бус хөрөнгө	151,300,000.00	151,300,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>181,220,804.79</u>	<u>237,309,073.17</u>
	НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		<u>4,274,850.00</u>
	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН		<u>4,274,850.00</u>
413	ӨГЛӨГ		<u>4,274,850.00</u>
41361	Байгууллагад өгөх өглөг		4,274,850.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>181,220,804.79</u>	<u>233,034,223.17</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	181,220,804.79	233,034,223.17
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	209,311,395.49	209,311,395.49
51101	Өмч: - төрийн	209,311,395.49	209,311,395.49
512	Хуримтлагдсан үр дүн	(28,090,590.70)	23,722,827.68
51210	Өмнөх үеийн үр дүн	(28,090,590.70)	(28,090,590.70)
51300	Тайлант үеийн үр дүн		51,813,418.38
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>181,220,804.79</u>	<u>237,309,073.17</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	975,268,000.00	1,841,847,300.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	65,354,000.00	144,970,200.00
120	Нийтлэг татварын бус орлого	65,130,000.00	115,473,200.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	65,130,000.00	115,473,200.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000.00	115,473,200.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,130,000.00	
140020	Бусад орлого	224,000.00	29,497,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	909,914,000.00	1,696,877,100
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	231,747,300.00	684,164,100
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	231,747,300.00	684,164,100
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	673,246,700.00	1,004,793,000
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	673,246,700	1,004,793,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,920,000.00	7,920,000.00
132001	Урсгал үйл ажиллагаанаас санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,920,000.00	7,920,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	990,829,925.60	1,790,033,881.62
21	УРСГАЛ ЗАРДАЛ	990,829,925.60	1,760,536,881.62
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	943,312,879.35	1,534,097,261.17
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	181,052,651.87	280,233,270.53
210101	Үндсэн цалин	115,470,928.87	157,002,755.99
210102	Нэмэгдэл	40,687,618.00	71,255,681.42
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,668,500.00	20,713,284.48
210104	Урамшуулал	14,225,605.00	31,261,548.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21,031,487.88	38,327,337.59
210201	Тэтгэврийн даатгал	13,855,487.88	25,095,541.05
210202	Тэтгэмжийн даатгал	1,821,548.52	4,264,358.95
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,435,200.00	2,168,338.04
210204	Ажилгүйдлийн даатгал	470,206.54	618,099.55
210205	Эрүүл мэндийн даатгал	3,449,044.94	6,181,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,920,000.00	4,510,000.00
210304	Байрны түрээс	4,920,000.00	4,510,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	8,157,726.00	63,831,742.77
210401	Бичиг хэрэг	3,208,600.00	3,702,730.00
210402	Тээвэр, шатахуун		7,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,818,652.00	2,285,580.77
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,228,097.00	3,598,000.00

210407	Аж ахуй материал худалдан авах зардалд		43,774,938.00
210408	Бараа материал акталсны зардал	1,902,377.00	3,370,494.00
210601	Багаж техник хэрэгсэл	91,200.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	375,775,560.00	7,339,200.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	374,472,860.00	4,094,200.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох		2,800,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,302,700.00	445,000.00
210807	Газрын төлбөр		
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	352,284,253.60	1,139,855,710.28
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	344,230,004.00	1,133,064,575.66
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,620,000.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6,434,249.60	6,791,134.62
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,517,046.25	226,439,620.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,360,000.00	190,614,500.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж урамшуулал		126,977,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		37,944,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000.00	25,693,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		32,415,120.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		32,415,120.45
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,157,046.25	3,410,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,157,046.25	3,410,000.00
28	Хөрөнгийн зардал		29,497,000.00
	Дотоод эх үүсвэрээр		29,497,000.00
223001	Бусад хөрөнгө		29,497,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>15,561,925.60</u>	<u>51,813,418.38</u>
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>15,561,925.60</u>	<u>51,813,418.38</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	<u>975,268,000.00</u>	<u>1,841,847,300.00</u>
	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	<u>65,354,000.00</u>	<u>144,970,200.00</u>
	Нийтлэг татварын бус орлого	<u>65,354,000.00</u>	<u>115,473,200.00</u>
	Төсөвт байгууллагын өөрийн орлого	<u>65,354,000.00</u>	<u>115,473,200.00</u>
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	50,000,000.00	115,473,200.00
120042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	15,130,000.00	
140020	Бусад орлого	224,000.00	29,497,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	909,914,000.00	1,696,877,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	231,747,300.00	684,164,100.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	231,747,300.00	684,164,100.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	673,246,700.00	1,004,793,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	673,246,700.00	1,004,793,000
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	4,920,000.00	7,920,000.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	4,920,000.00	7,920,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (II)	<u>975,268,000.00</u>	<u>1,762,069,975.00</u>
21	УРСГАЛ ЗАРДАЛ	975,268,000.00	1,762,069,975.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	927,750,953.75	1,404,500,354.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	179,293,339.75	281,451,192.23
210101	Үндсэн цалин	113,711,616.75	158,524,739.65
210102	Нэмэгдэл	40,687,618.00	72,177,899.22
210103	Унаа хоолны хөнгөлөлт	10,668,500.00	19,487,004.72
210104	Үр дүнгийн урамшуулал	14,225,605.00	31,261,548.64
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	22,790,800.00	38,631,399.55
210201	Тэтгэврийн даатгал	15,614,800.00	26,269,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,821,548.52	3,090,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,435,200	2,472,400.00
210204	Ажилгүйдлийн даатгал	470,206.54	618,099.55
210205	Эрүүл мэндийн даатгал	3,448,044.94	6,181,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,920,000.00	4,510,000.00
210304	Байрны түрээс	4,920,000.00	4,510,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	6,732,950.00	13,991,480.77
210401	Бичиг хэрэг	2,880,200.00	1,200,000.00
210402	Тээвэр, шатахуун		7,100,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,818,652.00	2,285,580.77

210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,034,098.00	3,405,900.00
	Эд хогшил урсгал засвар		13,886,500.00
210601	Багаж техник хэрэгсэл		13,886,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	380,343,560.00	12,718,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	376,240,860.00	12,218,000.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	2,800,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,302,700.00	500,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	333,670,304.00	1,039,311,782.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	332,050,304.00	1,039,311,782.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	1,620,000.00	
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	47,517,046.25	357,569,620.45
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,360,000.00	321,744,500.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал		37,944,500.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,360,000.00	283,800,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг		32,415,120.45
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг		32,415,120.45
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	46,157,046.25	3,410,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	46,157,046.25	3,410,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)		<u>79,777,325.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)		78,302,475.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ		78,302,475.00
2200	Дотоод эх үүсвэрээр		78,302,475.00
223001	Бусад хөрөнгө		28,022,150.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал		50,280,325.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)		<u>(78,302,475.00)</u>
	Нийт цэвэр мөнгөн гүйлгээ		<u>1,474,850.00</u>
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	1,474,850.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

/төгрөгөөр/

Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	209,311,395.49	(12,528,665.10)	196,782,730.39
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,311,395.49	(12,528,665.10)	196,782,730.39
Тайлант үеийн үр дүн		(15,561,925.60)	-15,561,925.60
2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,311,395.49	-28,090,590.70	181,220,804.79
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	209,311,395.49	(28,090,590.70)	181,220,804.79
Тайлант үеийн үр дүн		(51,813,418.38)	51,813,418.38
2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	209,311,395.49	23,722,827.68	233,034,223.17

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	684,164,100.00	651,748,979.55	32,415,120.45	95.3
21	УРСГАЛ ЗАРДАЛ	684,164,100.00	651,748,979.55	32,415,120.45	95.3
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	643,419,600.00	611,014,479.55	32,405,120.45	95.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	309,052,200.00	281,451,192.23	27,601,007.77	91.1
210101	Үндсэн цалин	176,340,000.00	158,524,739.65	17,815,260.53	89.9
210102	Нэмэгдэл	87,035,800.00	72,177,899.22	14,857,900.78	82.9
210103	Унаа хоолны хөнгөлөлт	31,594,000.00	19,487,004.72	12,106,995.28	61.7
210104	Урамшуулал	14,082,400.00	31,261,548.64	(17,179,148.64)	222.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	38,631,400.00	38,631,399.55	0.45	100
210201	Тэтгэврийн даатгал	26,269,400.00	26,269,400.00		100
210202	Тэтгэмжийн даатгал	3,090,500.00	3,090,500.00		100
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,472,400.00	2,472,400.00		100
210204	Ажилгүйдлийн даатгал	618,100.00	618,099.55	0.45	100
210205	Эрүүл мэндийн даатгал	6,181,000.00	6,181,000.00		
2104	Хангамж, бараа материалын зардал	15,436,000.00	13,991,480.77	1,444,519.23	90.6
210401	Бичиг хэрэг	1,200,000.00	1,200,000.00		100
210402	Тээвэр, шатахуун	7,100,000.00	7,100,000.00		100
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,036,000.00	2,285,580.77	750,419.23	75.3
210405	Хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгал	600,000.00		600,000.00	
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,500,000.00	3,405,900.00	94,100.00	97.3
	Эд хогшил худалдан авах зардал	65,800,000.00	64,166,825.00	1,633,175.00	97.5
	Багаж техник хэрэгсэл	45,800,000.00	44,420,600.00	1,379,400.00	96.9
	Тавилга	20,000,000.00	19,746,225.00	253,775.00	98.7
	Томилолт зочны зардал	1,000,000.00		1,000,000.00	
	Дотоод албан томилолт	1,000,000.00		1,000,000.00	
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	3,500,000.00	2,960,000.00	540,000.00	84.6
	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,500,000.00	2,460,000.00	40,000.00	98.4
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	500,000.00		500,000.00	

210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	500,000.00	500,000.00		100
2108	Бараа үйлчилгээний бусад зардал	210,000,000.00	209,813,582.00	186,418.00	99.9
210801	Бараа үйлчилгээний бусад зардал	210,000,000.00	209,813,582.00	186,418.00	99.9
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	40,744,500.00	40,734,500.00	10,000.00	100
2132	Бусад урсгал шилжүүлэг	40,744,500.00	40,734,500.00	10,000.00	100
213207	Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	37,944,500.00	37,944,500.00		100
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	2,800,000.00	2,790,000.00	10,000.00	99.6
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	684,164,100.00	651,478,979.55	32,415,120.45	95.2
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	684,164,100.00	651,478,979.55	32,415,120.45	95.3
131001	Улсын төсвөөс санхүүжих	684,164,100.00	651,478,979.55	32,415,120.45	95.3
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
	Мөнгө түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл				
62	АЖИЛЛАГСДЫН ТОО	8	8	8	100
620001	Удирдах ажилтан	1	1	1	100
620002	Гүйцэтгэх ажилтан	7	7	7	100
620003	Үйлчлэх ажилтан				

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,120,266,200.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,120,266,200.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	839,256,200.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,758,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,758,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	829,498,200.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	829,498,200.00
	Урсгал шилжүүлэг	281,010,000.00
	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	281,010,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,120,266,200.00
	Төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос	115,473,200.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	1,004,793,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,004,793,000.00

2.7 Төсвийн тохируулга

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Төсвийн тохируулга
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН	69,832,120.45
2	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	29,497,000.00
3	Нийтлэг татварын бус орлого	29,497,000.00
4	Бусад орлого	29,497,000.00
5	ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	40,335,120.45
6	Орон нутгийн төсөв	7,920,000.00
7	Урсгал санхүүжилт /орон нутаг/	7,920,000.00
8	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	68,357,270.45
9	УРСГАЛ ЗАРДАЛ	68,357,270.45
10	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	32,532,150.00
11	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	4,510,000.00
12	Байрны түрээс	4,510,000.00
13	Бараа үйлчилгээний бусад зардал	28,022,150.00
14	Бараа үйлчилгээний бусад зардал	28,022,150.00
15	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,410,000.00
16	Төвлөрүүлэх шилжүүлэг /Орон нутгийн төсөв/	3,410,000.00
17	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,474,850.00
18	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	1,474,850.00
19	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	1,474,850.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар:

Нийслэлийн биеийн тамир спортын газар нь шударга, ил тод, хуулийг дээдлэх, мэдлэг, чадвартай, мэргэшсэн тогтвортой, хариуцлага, ёс зүйтэй, бүтээлч, санаачилгатай, иргэд олон нийтэд түшиглэх, хяналт үр дүнг чухалчлах зарчмуудыг эрхэмлэж, биеийн тамир спортын үйлчилгээг нийслэл хотын айл өрх, иргэн бүрд хүргэж өндөр зэрэглэлтэй тамирчдын залгамж халааг тасралтгүй бэлтгэх орчин нөхцөлийг бүрдүүлэх эрхэм зорилготой.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар:

Тус газар нь Биеийн тамир спортын тухай хууль, Төсвийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, төрийн хэмнэлтийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай зэрэг хуулийг мөрдөн ажиллаж байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт гарчээ. Үүнд:

- ЗГ-ын 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн захиргааны төв байгууллагын төрийн захиргааны болон төрийн тусгай албан тушаалын цалингийн хэмжээ, Засгийн газрын агентлаг, нутгийн захиргааны байгууллага болон төрийн захиргааны бусад байгууллагын төрийн захиргааны албан тушаалын цалингийн хэмжээ, төрийн үйлчилгээний бусад байгууллага болон төрийн байгууллагын хэвийн үйл ажиллагааг хангахад туслах албан тушаалын цалингийн доод хэмжээ шинэчлэн баталсан.
- ЗГ-ын 2023 оны 301 дүгээр тогтоолоор "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, үр дүн, мэргэжлийн түвшинг үнэлэх журам" баталж 9 дүгээр сараас хэрэгжиж эхэлсэн.
- ЗГ-ын 442-р тогтоолоор Журам шинэчлэн батлах тухай" Засгийн газрын 2023 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 301 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журам"-ын тав дугаар бүлэгт өөрчлөлт орж 12 дугаар сараас хэрэгжиж эхэлсэн байна.
- ЗГ-ын 2022 оны 5 дугаар сарын 25-ны өдрийн 203 дугаар тогтоолоор "Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэх зарим арга хэмжээний тухай журам" тогтоолууд шинэчлэн батлагдсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөө дунд байна.

Дотоод аудитын нэгжгүй, дээд шатны байгууллагаас дотоод хяналт шалгалт хийгдээгүй тул аудитын үйл ажиллагаанд ашиглах дотоод хяналтын гүйцэтгэсэн ажил байхгүй байна.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийслэлийн биеийн тамир спортын газрын 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар: Биеийн тамир спортын газрын 2019 оны оны 12 дугаар сарын 24-ний өдрийн Б/5 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийслэлийн биеийн тамир спортын газрын 2023 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааны бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56,088.3 мянган төгрөгөөр буюу 30.9 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө		1,474.85	1,474.85
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	9,485.76	20,609.99	11,124.23
Үндсэн хөрөнгө	171,735.04	215,224.22	43,489.18
Нийт хөрөнгө	181,220.80	237,309.07	56,088.27
Өр төлбөр		4,274.85	4,274.85
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	181,220.80	233,034.22	51,813.42
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	181,220.80	233,309.07	56,088.27

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт орсон бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данснууд байна.

элэгдэх, аж ахуйн эд зүйлсийн зардлыг 94.1 мянган төгрөг, эд хогшил худалдан авах зардлыг 1,633.2 мянган төгрөг, томилолтын зардлыг 1,000.0 мянган төгрөг, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөрийн зардлыг 540.0 мянган төгрөг бараа үйлчилгээний бусад зардлыг 186.4 мянган төгрөг, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 10.0 мянган төгрөгөөр тус тус дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Биеийн тамирын уралдаан тэмцээн	110,000.0	110,000.0		100%
2	Нийтийн биеийн тамир	97,000.0	96,860.8	139.2	99.8%
3	Биеийн тамир спорт Үндсэн үйл ажиллагаа	436,419.6	404,143.6	32,275.9	0.92%
4	Нэг удаагийн тэтгэмж шагнал урамшуулал	40,744.5	40,744.5		100%
		684,164.1	651,748.9	32,415.1	95.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд Нийслэлийн Засаг даргын захирамжаар 1,004,793.0 мянга, төсөвт байгууллагын үйл ажиллагааны орлогоос 115,473.2 мянга, нийт 1,120,266.2 мянган төгрөгийн санхүүжилт оржээ. Үүнээс бараа үйлчилгээний бусад зардалд 829,498.2 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамжид 9,758.0 мянга, нэг удаагийн тэтгэмж, шагнал, урамшуулалд 281,010.0 мянга, нийт 1,120,266.2 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт 2 хөтөлбөрийн хүрээнд 6 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Доорх хөтөлбөрөөс хэрэгжилт дутуу арга хэмжээ байхгүй байна. Хөтөлбөрийн хүрээнд 956,509.8 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Мөнгөн хөрөнгө дансны үлдэгдэл 1,474.9 мянган төгрөг нь Баянгол дүүргийн биеийн тамир спорт хорооны техник хэрэгсэл нийлүүлсэн гэрээт ажлын барьцаа данс дахь үлдэгдэл байна.

Бараа материал дансны үлдэгдэл 20,609.9 мянган төгрөг болж 11,124.2 мянган төгрөгөөр өссөн нь худалдан авсан бусад хангамжийн материал зарцуулагдаагүй үлдэгдлээр тайлагнаснаас шалтгаалсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэлд ашиглалтгүй байгаа болон их хэмжээгээр худалдан авч нөөцөлсөн материал байхгүй байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 43,489.2 мянган төгрөгөөр өссөн нь Биеийн тамир спортын улсын хорооноос олгосон санхүүжилтээр хөрөнгө худалдан авснаас шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар цэвэр хөрөнгө өмчийн дүн өмнөх оноос 51,813.4 мянган төгрөгөөр өссөн байна. Энэ нь нэмэгдсэн хөрөнгөтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 974,210.3 мянга, нийт зарлагыг 974,210.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас биеийн тамирын уралдаан тэмцээний зардлыг 314,483.0 мянга, хангамжийн зардлыг 8,277.6 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний хөлсийг 5,400.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 6,400.0 мянга, нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлыг 6,800.0 мянган төгрөгөөр тус тус бууруулж, цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 6,464.5 мянга, эд хогшил урсгал засварын зардлыг 43,850.0 мянга, томилолт зочны зардлыг 1,000.0 мянган төгрөгөөр тус тус нэмэгдүүлж 684,164.1 мянган төгрөгөөр баталсан байна. Энэ нь төсвийн төслийг бодитой, үндэслэлтэй боловсруулаагүйгээс шалтгаалсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөвт тодотгол хийгдээгүй байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 684,164.1 мянган төгрөгийг улсын төсвөөс төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 684,164.1 мянга, орон нутгийн төсвөөс 7,920.0 мянга, бусад эх үүсвэрээс 29,497.0 мянган төгрөгийн санхүүжилт олгож, урсгал үйл ажиллагаанд 651,748.9 мянган төгрөгийг зарцуулж, үлдэгдэл 32,415.1 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 651,748.9 мянган төгрөг буюу 93,9 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлыг 27,601.0 мянган төгрөг, шуудан холбоо, интернэтийн зардлыг 750.4 мянган төгрөг, хог хаягдал зайлуулах хортон мэрэгчдийн устгал ариутгалын зардлыг 600.0 мянган төгрөг, бага үнэтэй түргэн

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэн үр дүн, зарцуулалт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр, арга хэмжээ	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	Нийтийг хамарсан цасны баяр, СӨБ, ЕБС-ийн багш нарт зориулсан багц сургалт, Улаанбаатар марафон-2023, Улаанбаатар-хад фестиваль, Алхацгаая, гүйцгээе хөдөлгөөн, явган алхалт, нутгийн захиргааны наадам	2023.01.01 2023.12.31	445,308 иргэн оролцож иргэдэд хүргэх биеийн тамир спортын үйлчилгээний чанар нэмэгдэнэ.	416,000 иргэн оролцсон	564,737.0	564,737.0
2	Даншиг наадам, Хүрээ цам үндэсний бөхийн барилдаан, үндэсний сур харваа	2023.08.05 2023.08.06	Иргэдэд хүргэх биеийн тамир спортын үйлчилгээний чанар нэмэгдэнэ.	Буриад, Өвөр монгол бөхийн ангиллаар 320 бөх оролцсон	260,700.0	260,700.0
3	Өвлийн спортын төрлүүд тэшүүр, гүйлтийн цана, уулын цана, мөсний сур, хоккей, мөсөн хананы авиралт	2023.01.01 2023.12.08	413,000 иргэн хамрагдаж өвлийн спортыг хөгжүүлж иргэдийг биеийн тамир спортоор хичээллэх нөхцөлийг бүрдүүлэн оролцоог нэмэгдүүлнэ.	Орон сууц гэр хорооллын мөсөн гулгуурын талбай, мишээл экспо, янзага, хандгайт, скай резорт, галуут тур цанын баазуудад зохион байгуулж 425,100 иргэн үүнээс 699 тамирчин хамрагдсан	56,900.0	56,900.0
4	24 спортын холбоодтой гэрээ байгуулан спортын тэмцээнүүд	2023.01.01 2023.12.31	Үндэсний спорт болон спортын бусад төрлүүдийг хөгжүүлж, тамирчдын	НЗД-ын нэрэмжит 9, Улаанбаатар хотын аварга шалгаруулах 18, бусад 30 тэмцээнийг зохион байгуулж 3758	73,925.0	73,925.0

			залгамж халааг бэлтгэнэ. 7888 тамирчин орно	багийн 7967 тамирчин оролцсон.		
5	Өсвөрийн хүүхэд багачуудын дунд Улаанбаатар лиг сагсан бөмбөг, волейбол, хөл бөмбөгийн фестиваль	2023.01.01 2023.12.31	Багийн спортын төрлөөр хүүхэд багачуудын бие бялдрыг чийрэгжүүлэх	Монголын хүүхдийн спортын VII наадмын нийслэлийн бүсийн тэмцээнийг зохион байгуулж 5 төрлөөр 298 байгууллагын 145,530 хүүхэд багачууд оролцсон	173.8	173.8
6	Е-спорт, холимог тулаан, засмал замын дугуйн тэмцээнийг Виртуал хэлбэрээр зохион байгуулсан	2023.01.01 2023.12.31	Е-спортыг хөгжүүлэх		74.0	74.0

3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл

Байгууллага нь худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулж батлуулдаггүй бөгөөд үндсэн үйл ажиллагааны төсвийн хүрээнд 111,760.32 мянган төгрөг, нэмэлт төсвийн хүрээнд 207,448.16 мянган төгрөгийн худалдан авалтыг тус тус хийсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Нийслэлийн биеийн тамир спортын газрын 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татварын тайлан хувь хүн тус бүрээр зөв тайлагнах, шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн оруулж хэвших зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Шонхор үнэлгээ Аудит ХХК-ийн захирал Д.Шийрэв, аудиторын туслах Ц.Дашдулам нар гүйцэтгэж, чанарын хяналтыг аудитын менежер Д.Уранчимэг,

Санхүү-нийцлийн аудитын хэлтсийн аудитын менежер Я.Алтанцэцэг, хэлтсийн дарга Х.Түвшинбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийслэлийн биеийн тамир спортын газар нь 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг 2024 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 02/33 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 990,829.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 9,908.3 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн.

Гүйцэтгэлийн материаллаг байдлыг 2023 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын дүн 1,790,033.9 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 17,900.3 мянган төгрөгөөр шинэчлэн тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага өмнөх онд хийгдэж байсан холбогдох арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн ажилласан байна. Үүнд:

Төрийн хэмнэлтийн тухай хуульд заасан хангамж болон үйл ажиллагаанд тавих хязгаарлалт, хэмнэлтийн горимыг мөрдөж ажилласан эсэхийг судалгаанаас харахад дэд дарга, орлогч дарга, зөвлөх албан тушаалын орон тоогүй, дуудлагын автомашин ашигладаггүй, төсвийн болон байгууллагын хөрөнгөөр бэлэг дурсгалын зүйлс худалдан аваагүй байна.

Худалдан авах ажиллагаатай холбоотой 99 гэрээ байгуулан ажилласнаас 270,818.6 мянган төгрөгийн 53 гэрээг Неон шоу ХХК, болон Никель дикель ХХК-тай байгуулж давуу тал олгосон, цахим дэлгүүрээс худалдан авалт хийгээгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө боловсруулан тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлж байх зөвлөмж өглөө.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан 487 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Нийслэлийн биеийн тамир спортын газар нь 2023 онд нийт үндсэн болон нэмэлт санхүүжилтийн 956,995.0 мянган төгрөгийн 122 мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 10 мэдээллийг хугацаа хоцроосон ба бусад мэдээллийн хугацаанд нь бүрэн оруулсан байна. Үүнд:

- Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт 9 мэдээ
- Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан 1 мэдээ

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгаж давтан гаргахгүй байх зөвлөмж өгсөн.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалт, болон бусад хууль, тогтоомжийн хүрээнд шалгасан зүйлийг холбогдох шалгуурт нийцээгүй гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татварыг тайлагнахдаа тухайн хувь хүн бүрээр тайлагнаагүй зөвхөн нярвын нэр дээр бөөн дүнгээр тайлагнасан 394,009.2 мянган төгрөгийн алдааг 2023 оны 4 улирлын тайланд залруулсан.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 3,359.0 мянган төгрөгийн зөрчилд өгсөн 4 зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан байна.

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	4	3,359.0	1	3,359.0	100%
Нийт дүн	4	3,359.0	1	3,359.0	100%

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн холбогдох заалтууд, Засгийн газрын 2021 оны 5 дугаар сарын 5-ны өдрийн 124 дүгээр "Босго үнэ шинэчлэн батлах тухай" тогтоол, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1."Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд заасан захиалагч нь тухайн жилд худалдан авах 10 сая төгрөгөөс дээш өртөг бүхий бараа, үйлчилгээний жагсаалтыг цахим дэлгүүрт байршуулах хүсэлтийг өмнөх онд худалдан авсан тоо хэмжээ, нэгж үнийн хамт төрийн худалдан авах ажиллагааны асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллагад хүргүүлэх гэсэн заалтуудыг мөрдөж ажилласан эсэхийг авч үзэх шаардлагатай.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 450,600.8 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 394,010.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 56,590.8 мянган төгрөгийн алдаанд 1 зөвлөмж өгсөн.

Залруулсан алдаа: Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын 4 улирлын тайланг 194 харилцагч тус бүрээр залруулан тайлагнасан.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Татварын тайлагналтай холбоотой асуудал

Илрүүлэлт: Суутгагчийн хувь хүнд олгосон орлогын албан татварын тайланг шалгаж үзэхэд 56,590.80 мянган төгрөгийг орлого олгосон хувь хүн тус бүрээр тайлагналгүй зөвхөн нярав Б.Дониддуламын нэр дээр бөөн дүнгээр тайлагнасан. Энэ нь Татварын ерөнхий хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1.анхан шатны баримт бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийг тогтоосон журам, нягтлан бодох бүртгэлийн стандартын дагуу төлбөрийн баримтад үндэслэн хөтөлж, татварын тайланг санхүү, аж ахуйн үйл ажиллагааны тайлан тэнцэлд үндэслэн үйлдэх; заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Зөрчлийг арилгаж, хувь хүн тус бүрээр задалж татварын тайланг засварлах

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 5 дугаар сарын 25 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/Мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээлэл тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Суутгагчийн хувь хүнд олгосон орлогоос суутгасан албан татварын тайлан 1 -р улиралд Б. Дониддулам 18,306.0 мянган төгрөг, 2-р улиралд Б.Дониддулам 49,676.0 мянган төгрөг, 3-р улиралд Б.Болорлхам 261,885.4 мянган төгрөг, 4-р улиралд 194 харилцагч 450,600.8 мянган төгрөгийг тус тус тайлагнасан бөгөөд мөн Б. Дониддулам дээр 56,590.8 мянган төгрөгийг бөөн дүнгээр тайлагнасан	1	450,600.8					1	394,010.0			1	56,590.8
Дүн	1	450,600.8						394,010.0				327,409.5

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган тегрегер/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс				Зөвлөмж	
	Төлбөрийн акт		Албан шаардлага		Төлбөрийн акт		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөө тайлан, оруулаагүй, байгууллагын бүтэц орон тоонд орсон өөрчлөлт, санхүүгийн тайлангийн зэрэг 10 мэдээ хугацаа хоцроож мэдээлсэн.	1	-					1	-
Дүн	1	-					1	-